

АРВАЙХЭЭР СУМЫН ӨЛЗИЙТ 4 ДҮГЭЭР БАГИЙН ЗАСАГ ДАРГА ШИЙРЭВНЯМБУУГИЙН АВИРМЭДИЙН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					Биелэл тийн хувь		
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин, биелэлт	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэл тийн хувь			
									3	4
1		2								
Зорилт 1. “Дээд шатны байгууллагуудаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг ханган ажиллах”										
1.	1.1. Тогтоол шийдвэрийг хяналтад авч хэрэгжүүлэх.	Хяналтад авсан заалтын хэрэгжилтийн хувиар	100	100	Тайлант онд хууль тогтоомж лавламжийн санд нийт 75 эрх зүйн акт, үүнээс шинээр баяжуулсан эрх зүйн актын тоо 14, эрх зүйн лавлагаа мэдээлэл өгсөн иргэдийн тоо 698, боловсруулсан гарын авлага 10, бусад мэдээллийн хэрэгслээр сурталчилсан 65 байна. Эрх зүйн мэдээлэл лавлагааны дийлэнх хувийг Нийгмийн халамжийн тухай хууль, Ахмад настны тухай хууль, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Малын хөлийн албан татварын тухай хууль, Иргэний хууль, цахим шилжилттэй холбоотой иргэдийн цахим ур чадвар хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлийн зөвлөгөө мэдээлэл бусад хууль тогтоомжууд эзэлж байна.			2024.01.02 2024.12.31	100	
		1.2. “Нээлттэй Өвөрхангай” хөтөлбөрийг сурталчлах. Улаанбаатар, Эрдэнэт, Дархан болон бусад хотуудаас	Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор	-	1	Нээлттэй Өвөрхангай хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар, Эрдэнэт, Баянхонгор, Дорнод, Дархан зэрэг аймаг, нийслэлээс шилжин ирсэн 5 өрхийн сургууль, цэцэрлэгийн насны нийт 9 хүүхдийг сургууль, цэцэрлэгт бүрэн хамруулсан.			2024.01.02 2024.12.31	100
			Хүсэлтийн шийдвэрлэлтийн хувиар	100	100	Тайлант хугацаанд Улаанбаатар, Эрдэнэт, Баянхонгор зэрэг аймаг, нийслэлээс 7 өрхийн 26 иргэн тус багт шилжин ирж, суурьшсан бөгөөд 1 иргэнийг улирлын чанартай ажлын байранд, 1			2024.01.02 2024.12.31	100

шилжин ирж байгаа өрхийн хүүхдүүдийг хамран сурах тойргийн ЕБС, СӨБ-д хамруулах.					иргэнийг байнгын ажлын байранд холбон зуучилж ажилд оруулсан.		
1.3. Сул ажлын байрны зарыг иргэдэд нээлттэй хүртээмжтэй хэлбэрээр хүргэх.	Иргэдэд хүргэсэн зарын хувиар <i>45 тий</i> <i>100%</i>	100 <i>20</i>	100 <i>30</i>		Аймгийн ХХҮГ болон бусад албан байгууллагын албаны цахим хаягаар зарласан нээлттэй ажлын байрны зарыг багийн цахим хаяг болон, групп чатаар түгээж, зар хүргэсэн. Үүний үр дүнд түр ажлын байранд 29, байнгын ажлын байранд 13 иргэн ажилд орсон.	2024.01.02 2024.12.31	100 <i>✓</i>
1.4. "Цахим шилжилтийг эрчимжүүлэх" зорилтод жилийн хүрээнд төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх.	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар	-	100		Цахим шилжилтийг эрчимжүүлэх зорилтот жилийн ажлын төлөвлөгөөг 3 зорилт, 10 арга хэмжээтэйгээр төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний биелэлт 93,2%-тай хэрэгжиж байна.	2024.01.02 2024.12.31	93
1.5. "Тэр бум мод" үндэсний хөдөлгөөнийг нутаг дэвсгэртээ зохион байгуулах, хэрэгжилтийг ханган ажиллах.	Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор	2	1		Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд багийн иргэдийг ногоон байгууламж нэмэгдүүлэх, айл бүр хашаандаа мод бут тарихыг байнга уриалан Хотын захирагчийн албанаас гаргаж байгаа шторк, гарын авлагыг багийн цахим хаягуудаар /Өлзийт 4 дүгээр баг/ дамжуулан мэдээлэл өгч ажиллаж байна.. Багийн нутаг дэвсгэрт ногоон байгууламж бий болгох зорилгоор 5 га газрыг хашаажуулсан.	2024.01.02 2024.12.31	100
	Ногоон байгууламж нэмэгдүүлсэн өрхийн тоогоор	180	200		Шинээр 12 өрх улиас, үхрийн нүд, буйлс, чацаргана, гоёлын жижиг мод, хайлаас зэрэг төрлийн нийт 78 мод тариалсан. Мөн Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГ-с тус багийн хашаандаа тарьсан модгүй ч, мод тарих сонирхолтой, модны нүхээ ухаж	2024.01.02 2024.12.31	100

					бэлдсэн 21 өрхөд тус бүр 3 настай 3 ширхэг хайлаас, 1 агч, 2 улиас нийт 63 мод өгч дэмжлэг үзүүлсэн.		
	Сургалт, мэдээлэлд хамрагдсан өрхийн тоогоор	50	60		Мод тарих аргачлал гарын авлагыг багийн ажлын албанаас бэлтгэн багийн 200 иргэнд тарааж, зөвлөгөө мэдээлэл өгсөн. Мод бут тарих захиалга өгсөн 21 өрхөд зөвлөмж өгсөн.	2024.01.02 2024.12.31	100
1.6. Багийн хэмжээнд улирал бүр нийтийн цэвэрлэгээг зохион байгуулж нэгдсэн хог тээврийн хуваарийн дагуу хог ачилтад хяналт тавих	Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор	4	4		Өвөл, хаврын улирлын нийтийн их цэвэрлэгээг 4 удаа зохион байгуулж, цэвэрлэгээнд давхардсан тоогоор нийт 152 иргэн оролцож, 20 тонн хогийг хогийн нэгдсэн цэг төвлөрүүлж ажилласан. Мөн хог ачилт, тээвэрлэлтийн хуваарьт хяналт тавьж, иргэдээс ирсэн гомдол, саналыг тухай бүрд шийдвэрлэж ажиллаж байна.	2024.01.02 2024.12.31	100
1.7. Агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж байгаа ажлыг дэмжиж, хамтран ажиллах.	Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор	2	2		Агаар орчны бохирдлыг бууруулах зорилгоор 2023-2024 оны өвөл шинээр шахмал түлш хэрэглэж буй 40 өрхөд угаар мэдрэгч суурилуулсан. Мөн орчны бохирдлыг бууруулах, хүүхэд багачуудад байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах мэдлэг хандлагыг төлөвшүүлэх зорилгоор багийн ажлын албанаас олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулсан "Хүүхэд байх хөөрхөн" арга хэмжээний хүрээнд "Хогоо хогийн саванд хаяж хэвшээрэй" видео сургалтыг зохион байгуулж, хүүхдүүдтэй нээлттэй ярилцсан. Сургалт арга хэмжээнд 75 хүүхэд, 32 эцэг эх хамрагдсан.	2024.01.02 2024.12.31	100
	Сайжруулсан шахмал түлшийг хэрэглээнд	5	-		Сайжруулсан шахмал түлш хэрэглэхээр хүсэлтээ өгсөн 15 өрх байна.	2024.01.02 2024.12.31	-

	нэвтрүүлсэн өрхийн хувиар						
	Шинээр эко, болон сайжруулсан нойл, муу усны цооногтой болсон өрхийн тоогоор	30	35		Эко 00 төсөлд хамрагдах хүсэлтэй өрхүүдийг 42 бүртгэн авсан. Төсөлд хамрагдахаар 35 өрх гүйцэтгэгч компанид 25 хувийн төлбөрөө шилжүүлж, 15 өрхөд эко 00 бүрэн хийж гүйцэтгэсэн. Үлдсэн 30 өрхтэй нэмэлт гэрээ байгуулж хавар хийхээр тохиролцсон.	2024.01.02 2024.12.31	100
1.8. Малчдын "Аравтын бүлэг"-ийг чадавхжуулах ажил зохион байгуулах, бүлгийн тоог нэмэгдүүлэх.	Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор	0	1		Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан мал аж ахуйн салбарт үүсэж болзошгүй гамшаас урьдчилан сэргийлэх, мал аж ахуйн үйлдвэрлэл, малчдын хоршоог дэмжих замаар тогтвортой хөгжүүлэх зорилгоор МУЗГ-ын 2024 оны 166 дугаар тогтоолоор баталсан "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ийг талаарх мэдээллийг малчдад сурталчилж, хоршоог улсын бүртгэлд бүртгүүлэх заавар, бүрдүүлэх материалыг хагас жилийн мал тооллогоор 50 өрхөд тарааж, мэдээлэл өгч ажилласан. Мөн "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий аймаг хариуцсан мэргэжилтэн ажиллахад багийн төвийн доод зааланд 25 малчин өрхөд мэдээлэл өгүүлж ажиллаа.	2024.01.02 2024.12.31	100
	Чадавхжсан Аравтын бүлгийн тоогоор	1	1		Д.Батбаатар даргатай аравтын бүлгийг УБ хотод зохион байгуулагдсан хоршооны сургалтад хамруулсан.	2024.01.02 2024.12.31	100
1.9. Өвөлжилтийн бэлтгэл хангуулах төлөвлөгөө боловсруулж, батлуулан хэрэгжилтийг	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар	100	100		Өвөлжилтийн бэлтгэл хангах 10 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулж сумын Засаг даргын орлогч Ц.Эрдэнэсүрэнгээр батлуулан биелэлтийг хангаж ажиллаа.	2024.01.02 2024.12.31	-

зохион байгуулах.	Төсөл хөтөлбөрт зуулчилж, сургалтад хамруулсан хувиар	10	105.	Малжуулах төсөлд 4 өрхийг хамруулж, нийт 32 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлээр өсвөрийн залуу мал худалдан авсан. ХХҮГ-аас хэрэгжүүлдэг Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт талх нарийн боов, түргэн хоолны чиглэлээр 1, Хүлэмжийн ногооны чиглэлээр 1, зөвлөх үйлчилгээний 1 зэрэг 3 төслийг зуучилж ажилласан. "Ногоо тарья" төсөлд багийн 3 иргэнийг хамруулсан. Эмэгтэйчүүдийн бизнес эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 1 иргэнийг зуучилсан. Аймгийн ХХҮГ, Улаан загалмайн холбоо хамтран зохион байгуулсан "Олон нийтийн оролцоонд түшиглэсэн өдрийн үйлчилгээ"-ний сургалтад 5 ахмадыг 7 хоног сургалтад хамруулсан.	2024.01.02 2024.12.31	100
	Төсөл хөтөлбөрт хамруулсан иргэний хувиар	100	100	Холбон зуучилсан нийт 13 төслийг дэмжүүлж, төсөлд бүрэн хамруулсан.	2024.01.02 2024.12.31	100
Зорилт 2. "Хууль болон бодлого шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах"						
2.1. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчилж, хэрэгжилтийг ханган ажиллах.	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар	100	100	Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчилсэн загварын дагуу боловсруулж батлуулсан. ЗГ-ын 2017 оны 67-р тогтоол, 2011 оны 339, 340-р тогтоолын дагуу 3 сарын 28-ны өдрийн 16:00 цагт улс орон даяар гамшгийн зарлан мэдээллийн дуут дохио дуугаргаж, дадлага сургуульд багийн иргэд багийн Нэгдсэн төвийн гадна талбайд цуглаж, 50 иргэн, 10 машин, 3 мотоцикл, 2 унадаг дугуй бэлэн жагсаж, дүн мэдээг ОБГ-т дамжуулсан.	2024.01.02 2024.12.31	100
2.2. Өвөрхангай аймгийн анхан шатны Улаан Загалмайн хороотой	Шинээр сайн дурын идэвхтэн гишүүдэд элсүүлсэн иргэний тоогоор	15	18	2023-2024 оны өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан аймгийн Улаан загалмайн хороотой хамтран зорилтот бүлгийн 12 малчин өрхөд өргөн хэрэглээний хүнсний тусламж үзүүлсэн. Тайлант хугацаанд шинээр сайн дурын идэвхтэн гишүүн элсүүлж, гишүүнчлэлийн татварыг төвлөрүүлж	2024.01.02 2024.12.31	100

хамтран ажиллах.	Гэрээний хэрэгжилтийн хувиар	100	100	ажиллаж байна. Улаан загалмайн сайн дурын идэвхтэн гишүүнээр 12 малчин элсүүлсэн.	2024.01.02 2024.12.31	100
2.3. Өрхийн эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулж, хамтран ажиллах.	Үзлэг шинжилгээнд хамрагдсан иргэний хувиар	105	105	Урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамрагдвал зохих нийт 3209 иргэнээс 2838 нь хамрагдсан. Үүнд: - Артерийн шпертензид хамрагдвал зохих 1511 иргэнээс 92,5 хувь - чихрийн шижин илрүүлэх шинжилгээнд хамрагдвал зохих 655 иргэнээс 70.1 хувь, - хөхний хавдар илрүүлэх үзлэгт хамрагдвал зохих 435 иргэнээс 100 хувь, - умайн хүзүүний эсийн шинжилгээнд хамрагдвал зохих 237 иргэнээс 66 хувь нь тус тус хамрагдаад байна.	2024.01.02 2024.12.31	100
2.4. Мал эмнэлгийн нэгжтэй хамтран ажиллах гэрээ байгуулах, хамтран ажиллах.	Гэрээний хэрэгжилтийн хувиар	100	100	"Үржин дэвжих" мал эмнэлэгтэй 2024 онд хамтран ажиллах гэрээг малын шүлхий, бруцеллёз, хачигтах, цусан халдварт, шар ширхтэх, шөвөг яр зэрэг өвчнөөс урьдчилан сэргийлэх, малчдын малын хашаа хороог халдваргүйжүүлэх, бэлчээрийн сэг зэм устгах, ариутгах, мэрэгч амьтдаас хамгаалах хор цацах зэрэг 11 заалттай байгуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Гэрээний биелэлт 50 хувьтай хэрэгжиж байна.	2024.01.02 2024.12.31	100
2.5. Хагас жил болон жилийн эцсийн мал тооллогын ажлыг зохион байгуулж, хуулийн хугацаанд программд оруулах.	Мэдээг мал тооллогын программд алдаагүй үнэн зөв оруулсан хувиар	100	100	2024 оны хагас жилийн малын түүвэр тооллогод тус багаас 40 өрх сонгогдож ирсэн бөгөөд тооллогыг журмын дагуу бүрэн зохион байгуулж, хагас жилийн тооллогын маягтад бичилт хийж, мэдээллийг малын программд шивж оруулсан. Жилийн эцсийн мал тооллогын хугацаа болоогүй байна. Хугацаа нь болохоор 100 хувь хамруулж, малын программд шивж оруулна.	2024.01.02 2024.12.31	100

2.6. "Багийн хамтарсан баг"-ийн үйл ажиллагааны тухайн жилийн төлөвлөгөөг батлах, удирдлага, арга зүйгээр ханган ажиллах.	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар	100	100	Хамтарсан багийн 2024 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 5 зорилт, 13 арга хэмжээтэйгээр боловсруулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд хамтарсан баг 3 удаа хуралдаж, 4 кейс дээр нь хяналт тавин ажиллаж байна. Хаасан 3 кейс	2024.01.02 2024.12.31	100
2.7. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих.	Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор	3	1	Тайлант хугацаанд тус багт цагдаагийн газрын 7 Мөрдөгчийн мэдэгдэл ирсэн бөгөөд мэдэгдлийн мөрөөр хэрэг, зөрчилд холбогдсон этгээдүүдтэй уулзаж, зөвлөгөө өгч, дахин хэрэг зөрчил үйлдэхгүй байх талаар баталгаа бичүүлж, соён гэгээрүүлэх сургалтад хамруулж, ажилд зуучлан ажиллаж байна. Тухайлбал аймгийн ГХУСАЗСЗ-с зохион байгуулсан "Одоо л больё" эрүүл мэндийн үзлэг, сургалт нөлөөллийн арга хэмжээнд дээрх хэрэг, зөрчилд холбогдсон 5 иргэнийг хамруулсан. 1 иргэнийг улирлын чанартай ажилд зуучилж ажилд оруулсан. Дээрлэхэл дэлгэрэх ёсгүй аяныг сурталчлах зорилгоор багийн ажлын албанаас олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулсан "Хүүхэд байх хөөрхөн" арга хэмжээний хүрээнд "Дээрлэхэл дэлгэрэх ёсгүй" видео сургалтыг зохион байгуулж, хүүхдүүдийг уриалгад нэгдэхийг уриалсан. Сургалт арга хэмжээнд 75 хүүхэд, 32 эцэг эх хамрагдсан. Хэсгийн ахлагч нарыг хувиар гарган эргүүл тогтмол хийлгэж байна.	2024.01.02 2024.12.31	100
2.8. Хөдөө аж ахуйн ХАА-1, ХАА-2, ХАА-3,	Мэдээний тоо	47	47	Статистикийн хугацаатай мэдээ тайлан болох Төл бойжилт, том мал, төл малын зүй бус хорогдлын мэдээ. ХАА-н программ. Мал тооллогын хугацаатай	2024.01.02 2024.12.31	100

	ХАА-5, ХАА-6, ХАА-7, ХАА-8, ХАА-9, ХАА-10 мэдээнүүдийг хугацаанд нь үнэн зөв гаргаж, нэгтгүүлэх.				мэдээ тайланг сум хариуцсан мэргэжилтэнд цаг хугацаанд нь бүрэн өгч, программд шивж оруулсан.		
	2.9. Багийн зохион байгуулагч, нийгмийн ажлтын удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах.	Өгсөн үүрэг даалгавар, арга зүйн зөвлөмжийн биелэлтийн хувиар	100	100	Багийн Засаг дарга нь зохион байгуулагч, нийгмийн ажлтын өдөр тутмын удирдлагаар ханган, хувийн зохион байгуулалт, сахилга, дэг журам, ёс зүй, ажлын хариуцлагыг өндөржүүлэн, иргэний хүссэн мэдээлэлд тулгуурлан үйлчилгээг түргэн шуурхай хүргэхэд гол анхаарлаа чиглүүлэн ажиллаж байна	2024.01.02 2024.12.31	100
	2.10. БИНХ-ыг зохион байгуулах, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах, биелэлтийг тайлагнах.	Зохион байгуулсан хурлын тоогоор	4	4	Арвайхээр сумын Өлзийтийн 4 дүгээр багийн иргэдийн Нийтийн Хурал улирал бүр хуралдаж, давхардсан тоогоор нийт 255 иргэн хуралдаа оролцсон.	2024.01.02 2024.12.31	100
		Гарсан шийдвэрийн хэрэгжилтийн хувиар	100	100	Багийн иргэдийн Нийтийн Хуралдаанаас гарсан 8 тогтоол, 2 хурлын тэмдэглэлийг албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу хөтөлж хугацаанд нь Арвайхээр сумын ИТХуралд уламжлан хүргэж ажилласан. Мөн 2 хуралдаанаас иргэдээс гаргасан нийт 15 саналыг дээд шатны байгууллагад уламжлан, шийдвэрлүүлж ажиллаж байна.	2024.01.02 2024.12.31	100
Зорилт 3. "Байгууллаганы гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх"							
3.	3.1. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай	Үүрэг даалгаврын хэрэгжилт хувиар	100	100	Байгууллагын шуурхай хурал болон бусад цаг үеийн хуралд тогтмол оролцож, удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган, ажиллаж байна.	2024.01.02 2024.12.31	100

хэрэгжүүлэх, удирдлагыг тухай бүр үнэн зөв мэдээллээр хангах.							
3.2. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хугацаанд нь шийдвэрлэж, хариуг өгөх.	Шийдвэрлэлтийн хувиар	100	100	100	Нийт 226 өргөдөл, гомдол ирснээс түлээ нүүрсний дэмжлэг хүссэн 58, эко 00 төсөлд хамрагдахыг хүссэн 42, эмчилгээний зардалд дэмжлэг хүссэн 35, шагнал хүссэн 16, эко 00 төсөлтэй холбоотой гомдол 12, төсөлд хамрагдахыг хүссэн 10, алдарт эхийн одон хүссэн 10, амьдрах орчны бохирдол хог, нохойтой холбогдолтой 33, ажилд орохыг хүссэн 6, гэр хүссэн 3 хүсэлт байна. Үүнээс 207 өргөдөл гомдлыг харьяаллын дагуу шилжүүлж шийдвэрлүүлж, 19-ийг шийдвэрлэж хариу өгсөн.	2024.01.02 2024.12.31	100
Зорилт 4. "Төрийн албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах"							
4.1. Хугацаатай албан бичиг, тайлан мэдээ, судалгааг бүрэн үнэн зөв гаргаж хугацаанд нь холбогдох газруудад хүргүүлэх.	Хугацаатай албан бичгийн хариуг хугацаанд хүргүүлсэн, хувиар	100	100	100	Хугацаатай албан бичгийн тоо 42 байгаа бөгөөд хариуг хугацаа хоцроолгүй холбогдох мэргэжилтэн, албан байгууллагад хүргүүлж, ажилласан. Үүнээс Цагдаагийн газрын Мөрдөгчийн мэдэгдэл 5, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраас 3 судалгаа, ГБХЗХГ-аас 2, Аймгийн Засаг даргын Тамгын газраас 6, Сумын Засаг даргын Тамгын газраас 3, бусад байгууллагуудаас 8 хариутай бичиг ирснийг Зохион байгуулагч, Нийгмийн ажилтанд цохолт хийн, үүрэгжүүлж, гаргасан судалгаа, тайланг хянан баталгаажуулж, хариуг хугацаа хоцроолгүй хүргүүлсэн.	2024.01.02 2024.12.31	100
	Хугацаатай мэдээ тайланг хугацаанд нь хүргүүлсэн, хувиар	100	100	100	Мэдээ тайлангийн графикайн дагуу улсын хэмжээний судалгаа болон албан ёсны статистикийн мэдээ, мэдээллийг холбогдох маягтаар гаргаж, мөн цаг үеийн шаардлагаар нэмэлтээр шаардсан мэдээллийг хугацаанд нь хүргүүлж ажилласан.	2024.01.02 2024.12.31	100

4.2. Байгууллагад мөрдөгдөж буй дүрэм журам, төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг мөрдөх, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, цаг ашиглалт, ажлын бүтээмж, хариуцлагыг дээшлүүлэх.	Ашиг сонирхлын болон ёс зүйн зөрчилгүй ажилласан байна.	-	-	Албан үүргээ гүйцэтгэхдээ ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах талаарх мэдлэг, мэдээллээ байнга дээшлүүлж, ашиг сонирхлын зөрчил үүсгэлгүй албан тушаалын чиг үүргээ үнэнч шударгаар биелүүлж, ажиллаж байна. Байгууллагын "Дотоод журам"-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж, ард түмэн, олон нийтэд үйлчлэх явдлыг өөрийн эрхэм үүргээ гэж үзэн хувийн хэрэгт ёс зүйн зөрчлийн тэмдэглэл хийлгэлгүй шударгаар ажиллаж байна.	2024.01.02 2024.12.31	
	Ажлын цагийн хоцрогдол, ашиглалтын хувиар	100	100	Ажлын шаардлага болон ачааллаас хамаарч өдөрт 10-аас доошгүй цагаар ажиллаж байгаа бөгөөд 80 гаруй илүү цаг болон шөнийн цагаар ажиллаж, нэг удаа ажил таслаагүй, хоцроогүй байна. Ажлын байранд архи согтууруулах ундаа хэрэглэх зөрчил гаргалгүй, хариуцсан ажлын чиглэлээр аймгийн МШУТөвийн утсаар нэр заасан гомдол гаргалгүй ажиллалаа.	2024.01.02 2024.12.31	100
4.3. Хяналт, шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Тухайлбал: Төрийн албан хаагчийн хувийн хэргийг журмын дагуу бүрдүүлсэн, төлөвлөгөө, тайлан мэдээ, албан бичиг боловсруулахад ЗГ-ын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам", Стандарт хэмжилзүйн газрын даргын 2021 оны С/30 дугаар тушаалаар батлагдсан MNS5140-1:2021 баримт бичгийн стандартыг мөрдөж ажиллаж байна. Багийн ажлын албаны мэдээллийн самбарын мэдээллийг тогтмол шинэчилж, цахим хуудсаар зар мэдээлэл, эрх зүйн мэдээлэл зэргийг түгээн иргэдийн мэдэх эрхийг ханган ажиллаж байна. Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлт 50 хувьтай.	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар	100	50	Хяналт, шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Тухайлбал: Төрийн албан хаагчийн хувийн хэргийг журмын дагуу бүрдүүлсэн, төлөвлөгөө, тайлан мэдээ, албан бичиг боловсруулахад ЗГ-ын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам", Стандарт хэмжилзүйн газрын даргын 2021 оны С/30 дугаар тушаалаар батлагдсан MNS5140-1:2021 баримт бичгийн стандартыг мөрдөж ажиллаж байна. Багийн ажлын албаны мэдээллийн самбарын мэдээллийг тогтмол шинэчилж, цахим хуудсаар зар мэдээлэл, эрх зүйн мэдээлэл зэргийг түгээн иргэдийн мэдэх эрхийг ханган ажиллаж байна. Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлт 50 хувьтай.	2024.01.02 2024.12.31	100
4.4. Байгууллагаас зохион	Хамрагдсан арга хэмжээний хувиар	100	100	Байгууллагаас зохион байгуулсан олон нийтийн арга хэмжээ, зохион байгуулалтад идэвхтэй оролцож ажиллалаа. Тухайлбал: Үндэсний бөхийн	2024.01.02 2024.12.31	100

байгуулсан арга хэмжээнд идэвх санаачилгатай оролцох.	Арга хэмжээний тоогоор	1	1	хүүхдийн улсын аварга шалгаруулах анхдугаар барилдааны зохион байгуулалтад ажилласан. ✓ Байгууллагын аварга шалгаруулах волейболын тэмцээнд оролцсон. Байгууллагаас зохион байгуулсан бүхий л арга хэмжээнд идэвхтэй оролцож байна.	2024.01.02 2024.12.31	100
4.5. Байгууллага, багт туршлага болохуйц шинэлэг ажлыг зохион байгуулах.				2024 оны Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг "Хүүхэд байх хөөрхөн" уриатайгаар 05 сарын 31-нд сургалт, нөлөөллийн арга хэмжээ болон баярын арга хэмжээг хослуулан зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээ нь хувийн хэвшлийн аж ахуй нэгжийг татан оролцуулснаараа онцлог. Тус багт хагас, бүтэн өнчин болон зорилтот бүлгийн 105 хүүхэд байдаг бөгөөд 2-14 насны 75 хүүхдийг тус арга хэмжээнд хамруулж, 2 төрлийн сургалт, "Зуны амралтаа зугаатай өнгөрүүлээрэй" зөвлөмжтэй чихрийг тараасан. Энэхүү арга хэмжээнд багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Шаргын хүлэг 15, Оч-Ир маркет 15, Баянбуурал 15, Самарт 15, Цахир 5, Их хайрхан 10 нийт 75 бэлэг өгч нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэн хамтарч ажиллалаа. Дээрх дэлгүүрүүдэд багийн ажлын албанаас "Нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэгч" аж ахуй нэгж батламжийг өгсөн. 10 дугаар ангийн хүүхдүүдийг хамруулсан сэтгэл зүйн мэдээлэл өгөх сургалт арга хэмжээг 2024 оны 11 дүгээр сарын 20 нд дэлхийн хүүхдийн өдрийн хүрээнд зохион байгуулсан. Электрон тамхины хороо нөлөө зэрэг арга хэмжээг зохион байгуулсан.		
НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)						
д/д	Нэмэлт үүрэг, даалгавар	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Гүйцэтгэлийн түвшин		Биелэл тийн хувь
				Хүрэх түвшин	Хүрсэн түвшин, биелэлт	
1.	1 Арга хэмжээ 1. Багт хийгдэж Багт хийгдэж	2 Багт хийгдэж буй бүтээн	3 1	4 -	5 Замын орц гарц засварлах, тоглоомын талбай засварлах, ногоон байгууламж бий болгох 5 га	6 2024.01.02 2024.12.31
						7 100

	буй бүтээн байгуулалтын ажилд хяналт тавьж ажиллах	байгуулалтын ажилд хяналт тавих			хашаа барих ажил зэрэг багт хийгдэж буй бүтээнг байгуулалтын ажилд хяналт тавьж ажилласан.		
2.	Арга хэмжээ 2. Хархорины Солонго асрамжийн газарт хүмүүжиж буй багийн бүтээн өнчин хүүхдийг эргэж очиж, уулзан 300,000 төгрөгийн хувцас, бэлэн мөнгө өгч дэмжлэг үзүүлсэн.	Хархорин явах ажлын хэсэгт орж ажиллах	-	1		2024.01.02 2024.12.31	100
3.	Арга хэмжээ 3. Багийн иргэдэд зориулсан арга хэмжээ зохион байгуулах	Зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах	2	3	Хүүхдийн баярт зориулсан "Хүүхэд байх хөөрхөн" арга хэмжээг зохион байгуулж зорилтот бүлгийн 75 хүүхдийг хамруулж, 100 хүүхдэд баярын бэлэг өгсөн. Ахмадын баярын арга хэмжээг 11 сарын 13-нд зохион байгуулж, 89 ахмад оролцсон. Ахмадуудын дунд 4 төрлийн тэмцээн зохион байгуулж, эхний 3 байрыг шалгаруулж, урамшуулсан. Дэлхийн хүүхдийн өдөрт зориулсан "Найз байя" сэтгэл зүйн сургалтыг зохион байгуулж, ахлах ангийн 28 сурагч хамруулсан.	2024.01.02 2024.12.31	100

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Гүйцэтгэлийн түвшин			Биелэл тийн хувь
				Хүрэх түвшин	Хүрсэн түвшин	Эхэлсэн дууссан хугацаа	
1.	Монгол бичгийн сургалтад хамрагдах	Сертификат	Анхан	-	5	2024.01.02 2024.12.31	100

2.	Орон нутгийн хөгжлийн сангийн хяналт-шинжилгээ, үнэлгээний сургалтад хамрагдах	Сертификат	Анхан	Дунд	цахим сургалтад амжиллтай суралцаж үнэмлэх авсан. Орон нутгийн хөгжлийн сангийн хяналт, шинжилгээ, үнэлгээний сургалтад хамрагдаж, сертификат авсан.	2024.01.02 2024.12.31	100
----	--	------------	-------	------	---	--------------------------	-----

ТАЙЛАН ГАРГАСАН:
ӨЛЗИЙТ 4 ДҮГЭЭР БАГИЙН
ЗАСАГ ДАРГА


..... /Ш.АВИРМЭД/

2024.11.24